



НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар А/01

Улаанбаатар хот

Байгуулалтын бүтэц өөрчлөн батлах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3 дахь заалт, Нийслэлийн засаг даргын 2014 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын бүтэц, орон тоог батлах тухай А1047 тоот захирамж, “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.5, 5.1.8 дахь заалтыг тус тус ҮНДЭСЛЭН ТУШААХ НЬ:

1. Байгууллагын ажилчдын үр дүн, ур чадварыг сайжруулах зорилгоор дотооддоо бүтцээ өөрчлөн байгуулсугай.
2. “Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн бүтцийг нэгдүгээр хавсралтаар, зохион байгуулалтын ерөнхий бүдүүвч зургыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
3. 2019 оны 01 дүгээр сарын 02-ны дотор албан хаагч бүртэй Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулахыг Хуулийн мэргэжилтэн, хүний нөөц /Б.Ариунбилэг/-т даалгасугай.
4. Байгууллагын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан албан хаагчдын /албан тушаалын/ тодорхойлолтыг 2019 оны 01 дүгээр сарын 15-ны дотор холбогдох журмын дагуу шинэчлэн боловсруулахыг Төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх хэлтсийн дарга Н.Пүрэвсүрэн, Хуульч, хүний нөөцийн мэргэжилтэн Б.Ариунбилэг нарт үүрэг болгосугай.
5. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Хуульч, хүний нөөцийн мэргэжилтэн /Б.Ариунбилэг/-т үүрэг болгосугай.

ДАРГА  С.БАТЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТ
НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨААТҮГ
ТТ58651 м. 5980683